

ШИВЭЭГОВЬ СУМЫН МЭДЭЭ


*2023 оны 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар
сарын 03-ны хооронд хийгдсэн ажлуудаас*





УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, нээлттэй хүргэх ажлын хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдахад мэдээлэл зөрүүтэй өрхийн мэдээллийн зөрүүг арилгах зорилгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Авто тээврийн үндэсний төв гэсэн 5 байгууллагын хамтарсан баг 2023 оны 01 сарын 31-ний өдөр Шивээговь суманд “Нээлттэй Говьсүмбэр” өдөрлөгийг зохион байгуулж, 177 иргэний мэдээллийг шалгаж, өрхийн мэдээллийн зөрүүг арилган, иргэдэд зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласан.





УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монголчуудын дунд уламжлагдан ирсэн өвлийн спортыг сэргээн хөгжүүлэх, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор уламжлал болгон жил бүр зохион байгуулдаг “Цас мөсний баяр-2023” арга хэмжээ зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд багуудын дунд:

- △ Багийн мэндчилгээ
- △ Хөгжөөнт буухиа тэмцээн
- △ Тэшүүр
- △ Олс таталт
- △ Үндэсний хувцастай хос
- △ Мөсний шагай гэсэн төрлүүдийг зохион байгууллаа.

Тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцож багийн нийт дүнгээрээ 1,2,3 дугаар байрыг шалгаруулж

- ♣ 1-р байранд Шивээговь сумын Цагдаагийн хэлтсийн хамт олон
- ♣ 2-р байранд Шивээговь сумын ЗДТГазрын хамт олон
- ♣ 3-р байранд Шивээговь сумын 3 дугаар Цэцэрлэгийн хамт олон тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав.



“Цас мөсний баяр-2023” арга хэмжээ





УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



"МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ"

ҮНДЭСНИЙ ЗӨВӨЛГӨӨН УУЛЗАЛТАНД ГОВЬСҮМБЭР АЙМГААС 31 МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮД ОРОЛЦОЖ БАЙГАА БӨГӨӨД ШИВЭЭГОВЬ СУМААС 8 ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОРОЛЦСОН.

Энэхүү зөвлөгөөнөөр малчин эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм соёлын хүрээнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдэж болох санал, шаардлагыг төрийн холбогдох талуудад хүргүүлэх Зөвлөмжийг гаргах юм.

Мөн малчин эмэгтэйчүүд нүүдэлчин ахуй соёл, мал аж ахуйг хөгжүүлэхэд хэрхэн манлайлал үзүүлж болох санал санаачилгуудыг дэвшүүлэхээр ажиллаж байна.

Малчин эмэгтэйчүүд нь зөвлөгөөн, сургалт, лекц, хавдрын үзлэг, оношилгоонд хамрагдахаас гадна соёлын арга хэмжээ гээд 3 өдрийн цогц арга хэмжээнд оролцсон юм.



УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын хог хаягдлын асуудалтай холбоотойгоор Сумын засаг дарга, 1-р багийн засаг дарга, 1-р багийн Иргэдийн нийтийн хурлын дарга, Тохилог сууц СӨХ-ийн дарга нарыг хүлээн авч уулзалт хийлээ. Уг уулзалтаар хог хаягдлыг цэвэрлэх зайлуулах, СӨХ-ийн үндсэн үүрэгт ажлыг сайжруулах талаар харилцан тохиролцож, цаашдын ажлын төлөвлөгөөг хэлэлцэн, СӨХ-ийг иргэдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллаж, орчны бохирдлыг бууруулах талаар үүрэг өгч ажиллалаа.



2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайланг ОНХС-ийн мэргэжилтэнгүүдийн раге хуудсанд байршуулаад байна. Мөн ОНХС-ийн шилэн дансны мэдээллийг цаг тухай бүрт нь оруулан ажиллаж байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР

Сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/06 дугаар захирамжаар Малын гоц халдварт өвчний улмаас суманд хязгаарлалтын дэглэм тогтоон хяналтын пост ажиллуулж байгаатай холбогдуулан гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамгаалан ажиллах арга хэмжээний 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал”-аас 5,000,000 төгрөгний төсвийг зарцуулахаар төлөвлөгдсөн.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР



БОЛОВСРОЛЫН ТАЛААР

2023 оны шилдэг илтгэл “БОЛОВСРОЛ ДАХЬ ЁС ЗҮЙН АСУУДАЛ ШИЙДЭЛ” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын 2 дүгээр шатны уралдаан 01 сарын 27 нд Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан. Үүнд сургуулийн хэмжээнд 1-р шатанд шалгарч тэргүүн байр эзэлсэн Н.Баярцэцэг, Р.Алтанцэцэг, С.Долгорсүрэн багш нарын бэлтгэсэн “Амьдралд хөтлөгч-Анги удирдсан багш” сэдэвт илтгэл амжилттай оролцлоо.





“Аймгийн төрийн байгууллагуудтай танилцуулах, тухайн мэргэжлийн онцлог, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар ойлголттой болгох ажлын хүрээнд Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан арга хэмжээнд тус сургуулийн сэтгэлзүйч, сургуулийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон тооны бус зөвлөлийн сурагчид оролцов.



ЦАГДААГИЙН ХЭСЭГ

ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ, ХЭРГИЙН ТАЛААР :

Сүүлийн 14 хоногийн байдлаар иргэд, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 2, зөрчлийн шинжтэй 4 гомдол мэдээлэл шалгасан байна.

Зөрчлийн 4 гомдол мэдээллийг хүлээж авч шалагсанаас 2 гомдол мэдээллийг хялбаршуулсан журмаар шийдэж, 2 гомдол мэдээлэлд зөрчлийг хэрэг нээсэн.

Гэмт хэргийн шинжтэй 1 гомдол мэдээллийг хаах саналтай Аймгийн прокурорын газарт хүргүүлсэн.



Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр

Сумын 1,2-р багийн нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явганаар болон хөдөлгөөнт эргүүлийг тогтмол хийн ажиллаж байна. Эргүүлийн хугацаанд гудамж талбайд согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж биеэ авч явах чадваргүй болсон 9 иргэнийг ар гэр, асран хамгаалагчид нь өгсөн. Аймгийн цагдаагийн хэлтсийн ЭСББайранд 3 иргэнийг хүлээлгэн өгсөн

Монгол улсын зөрчлийн тухай хуулийн 5.1.1, 5.1.2, 6.3.1 дугаар зүйл заалтуудыг зөрчсөн 8 иргэнийг 175000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч ажилласан.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн, 26 тээврийн хэрэгсэлийн жолоочид Зөрчилийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 1.150.000 мянган төгрөгөөр торгож ажилласан.

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 1 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж 400.000 торгох арга хэмжээ авч ажилласан.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Торгууль нөхөн төлүүлэлт” арга хэмжээний хүрээнд 8 жолоочийн 160,000 төгрөгний торгуулийг нөхөн төлүүлж ажилласан.





ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Амбулаторийн үзлэг - 322

- Идэвхитэй хяналт- 42
- Урьдчилан сэргийлэх үзлэг- 18
- Нярайн гэрийн эргэлт- 18
- Томуу 0-5 хүртэлх насны хүүхэд- 54
- Эрүүл мэндийн даатгалын оношлогоо шинжилгээ, өдрийн эмчилгээ зэргээр тусламж үйлчилгээ явуулж байна.

**Түргэн тусламжийн
дуудлагын төрөл, тоо
хэмжээ**

Нийт дуудлага-36

Алсын дуудлага-0

Төвийн дуудлага-36

Том хүн-13

Хүүхдийн дуудлага-23

Осол гэмтэл-0

Стационари үйл ажиллагаа

Хэвтэн эмчлүүлэгчид нийт-22

Үүнээс:

❖ Дотор-8

❖ Хүүхэд- 14

СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

ХАБ-ын, Чанар аюулгүй
байдлын дотоод сургалт
зохион байгуулж
ажиллалаа. Нийт 16
ажилтан хамрагдав.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн боловсрол олгох рaгe хуудас болон шивээговь нэгдсэн зарын дээр ард иргэдэд эрүүл мэндийн мэдээ, нийгмийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан богино хэмжээний бичлэг зэрэг Ковид19-ын мэдээлэл зэргийг цаг алдалгүй оруулж ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материалын хүрэлцээтэй байна. Эм тарианы хангалт хийгдсэн одоогийн байдлаар хүрэлцээтэй байна.

АНХААРАЛ ХАНДУУЛСАН
ЯВДАЛД БАЯРЛАЛАА.

